



**УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ**

2016 оны 08 сарын 30 өдөр

Дугаар 0140


Улаанбаатар хот

**Шагнах тухай**

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9 дэх заалт, Ерөнхий менежерийн шагналын журмын 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барилгын салбар үүсч хөгжсөний 90 жилийн ой болон "Асем-11" уулзалтын бэлтгэл ажлын хүрээнд ажлын хэсэгт орж, идэвх санаачлагатай ажиллан, нийслэл хотын хөгжил, бүтээн байгуулалт, иргэдийн ая тухтай эрүүл аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулж ажилласан Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газрын архитектур дизайны хэлтсийн дизайнер Хүрэлбаатарын Мөнх-Энэрэл, Амгалангийн Энхнаран, Лхамдашийн Булган, Дахин төлөвлөлтийн хэлтсийн архитектор Эрдэнийн Мөнх-Эрдэнэ, Барилга хот байгуулалтын хэлтсийн хот байгуулалтын мэргэжилтэн Пэрэнлэйн Мөнгөнчимэг, Барилгын чанар, аюулгүй байдлын хэлтсийн барилгын инженер Цогтбаярын Хулан нарыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн "Өргөмжлөл"-өөр тус тус шагнасугай.

2. Өргөмжлөлийг дагалдах тус бүр 20 000 /хорин мянга/ төгрөгийг өөрийн байгууллагын төсвөөс шийдвэрлэж өгөхийг байгууллагын удирдлагад даалгасугай.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД  
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Т.ГАНТӨМӨР

УХА0501 9077367